



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

### Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мөнх даатгал” ХХК-ийн “Малын индексжүүлсэн даатгал”-ын бүтээгдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал”-ын бүтээгдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Мөнх даатгал” ХХК /Т.Оюунгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1-д заасан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Мөнх даатгал” ХХК /Т.Оюунгэрэл/-д анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



F:\ajil 2020\Blank\Togtool.doc

15100000025

Санхүүгийн зохицуулах хорооны  
2020 оны 01 сарын 15 өдрийн  
124-р тогтоолын нэгдүгээр хавсралт



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Мөнх даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Малын индексжүүлсэн даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Мал, амьтдын даатгал
4.	Даатгалын зүйл	Тэмээ, адуу, үхэр, сарлаг, хонь, ямаа
5.	Даатгалын эрсдэл	Дараах шалтгааны улмаас үүссэн малын хорогдол: - Байгалийн хүчит салхи, цасан болон шороон шуурга, мөндөр, үер, хүйтэн бороо, аянга, ой хээрийн түймэр, ган зуд, газар хөдлөлт, ус шаварт унаж шигдэх, ургамал бодисоос хордох; - Ахуйн осол эрсдэл /гал, түймэр, дэлбэрэлт, гэмтэл, бэртэл, бүтэлт/ - Хулгайд алдах, сураггүй алга болох, чоно нохойд баригдах.
6.	Даатгалын гэрээний хугацаа	1 жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	10 бүлэг, 93 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 032 тоот шийдвэр
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Б.Баярмагнай
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Бизнес хөгжлийн газрын захирал Ч.Мөнхдөл